

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2019 ОНЫ II УЛИРЛЫН ТАЙЛАН**

2019.07.03

Улиастай

Завхан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.


Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч шийдвэрлэн хариуг өгч, бусад өдрүүдэд хэлтсийн дарга нар иргэдийг хүлээн авч уулзаж өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Иргэдээс аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 2019 оны II улиралд 95 өргөдөл ирүүлсэнээс 91 өргөдлийг шийдвэрлүүлж 4 өргөдөл шийдвэрлэх хугацаа нь хүлээгдэж шийдвэрлэлт 95,7 хувьтай байна.



Нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс 1930 өргөдөл гомдлыг хүлээн авч 1784 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 24 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж, 1 өргөдөл хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 119 өргөдөл

хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92,4 хувьтай байна. Цахимаар буюу Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвөөр уламжлан 8, аймгийн Засаг даргын иргэдээ сонсох 70461212 утсанд 45 иргэн хандсан байна.



Өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр дүгнэлт хийж, хяналт шинжилгээ үнэлгээг хийж биелэлтийг тооцон ажиллаж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	148	144	15	-	4	97,2%
2	Нутгийн захиргааны байгууллага	1930	1784	24	1	119	92,4%
2019 оны II улиралын дүн		2078	1928	39	1	123	92.7%

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	ЗГИОНХ төвөөр	Цахим хэлбэрээ	Утсаар хандсан	Биеллэн уулзсан	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	148	95	8	-	45	-	-
2	Нутгийн захиргааны байгууллага	1930	1872	0	3	10	45	0
2019 оны II улиралын дүн		2078	1967	8	3	55	45	0

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Завхан аймаг	Нийт 2078 өргөдлөөс Хүсэлт 1600 /77% Санал 436 /21% Гомдол 42 /2% 1. “Ард иргэдээ сонсох аян”-ны хүрээнд аймгийн нийт өрхийн 60 хувиар нь орж тэдний санал, хүсэлтийг сонсодог болоод байна. 2. Хэлтэс, агентлаг, албан байгууллагын удирдах ажилтануудыг хамруулан зохион байгуулдаг “Шуурхай хурал”-аар иргэдээ сонсох 70461212 утсанд хандсан асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. 3. “Аймгийн Засаг дарга ард иргэдээ сонсож байна” шууд нэвтрүүлэгт оролцож иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авч шийдэрлэн ажиллаж байна.

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Л.ЛХАМСҮРЭН

ТАЙЛАНГ НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ЯДАМЦОО